

МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛЦЭД “ТЭНЭГ” ХЭМЭЭХ УТГЫГ ИЛЭРХИЙЛЭХ НЬ
Expressing the meaning of “stupid” in phrases in Mongolian Language

*Б.Мөнгөнцэцэг**

Хэлц нэгж нь тухайн улс үндэстний сэтгэлгээний хэв шинж, ертөнцийг таньсан байдлынх нь илэрхийлэл болж байдаг тул яагаад ингэж нэрлэж хэвших болсон шалтгаан, үүсгэл санааг ухаарч таних нь чухал юм. Хэл шинжлэлч эрдэмтдийн үзэж буйгаар, хэлц нэгжийг үндэстний сэтгэлгээний онцлогийг тайлбарлах гол судлагдахуун болгохдоо тухайн үндэстний нийгэмшсэн ухамсар төлөвшихөд байгалийн юм үзэгдлийг тусган ухаарсан сэтгэхүй хийгээд сэтгэлгээний хэв шинж (stereotype)¹ болон түүнийг илэрхийлэх тогтсон жишиг хэмжүүр (эталон)²-ийг илрүүлэн тайлбарлах хэрэгтэй хэмээн үздэг.

Бид энэхүү өгүүлэлд “тэнэг” гэсэн ойлголтыг илэрхийлэх хэлцийн жишиг хэмжүүрийг тогтоон, яагаад ингэж хэвших болсныг тайлбарлахаар зорьсон болно. Утга санаа, референт хоёрын харьцаа хамаарлыг илэрхийлдэг мөн чанар нь уламжлалт ойлголтоор, танин мэдэхүйн дүр буюу ухагдахуун, харилцааны тодорхой нөхцөл байдлын дүр буюу утга санааны аль аль нь биш, харин тэмдэглэгдэхүүний тухай хэв шинжит мэдлэг буюу түүний үүсгэмэл хэв шинж байх ёстой³ гэж үзсэнийг бид аргагүйн чухал баримжаа болгон авч үзсэн болно.

Монгол хэлнээ “тэнэг” хэмээх утгын хүрээнд

- тархи (толгой) нь эргэсэн;
- хатиг/чүдэнз толгойлох;
- хүүдэг нь битүү;
- эргүү төлөг (эргүү мал);
- төөрсөн гөлөг/төөрүүлсэн нохой;
- дон хөдлөх;
- чангаагаад сунахгүй, чанаад шалчийхгүй;
- хойшоо харсан нүх;
- богино жолоотой;
- доодохоосоо долоон доор;
- ухаан сэхээ муутай;
- ухааныг уяж болохгүй, санааг савлаж болохгүй;
- малгай, толгой хоёр нь адилхан;
- усан /махан мануухай/ хөндий/хоосон/хөлдүү/гэсдэггүй/ махан толгойт, усан тархи;
- чих нь цоорхой;
- арилсан дотортой;
- гавал нь гашилах, тархи нь гашилсан
- үхэр хэдгэнийг дээсээр бугуйлдах;
- мэдрэл дээр нь мэлхий шээх;
- ухаанд нь ухна үхсэн, санаанд нь сарлаг үхсэн;
- ухаанд нь ус орж, санаанд нь шавар орох;
- ухаан нь уландаа орох;
- ухаан нь ууцандаа, санаа нь сүүжиндээ;
- амьтан болох;
- ягшгалдай болох⁴ ;

* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш, доктор (Ph.D)

¹ Ж.Баянсан. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, Уб., 2002, 2;

В.А.Маслова. Лингвокультурология. М., 2002, 108-110 зэрэг номоос үзэж болно.

² Мөн тэнд

³ В.Н.Телия. Русская фразеология. Семантический, прагматический и лингвокультурологические аспекты. М., 1996, 94

⁴ “тэнэг ажил хийх” гэсэн санаатай хэлц. Урьд нэгэн хүн тулгаа тэмээний үдээрээр дангинатал үдчихээд “За одоо ягшгалдай болсон шүү” гэж хэлсэн гэдэг. Тэр цагаас хойш “ягшгалдай болох” гэсэн нэгэн аман хэлц монголчуудын дунд дэлгэрчээ. (Д.Баттогтох. Үлгэрийн хэлц үгийн толь. Уб., 2013, 91)

Б.Мөнгөнцэцэг

- хоёр үгний утга мэдэхгүй, хоймсон дээсний эрч эрхээхгүй;
(гурван үгний утга мэдэхгүй, гурамсан дээсний эрч эрхээхгүй)
- азаргаа унаад адуугаа эрсэн


гэхчлэн ёжилж егөөдсөн, доромжлон доршоож үзсэн, харааж зүхсэн, өрөвдөж харамссан зэрэг утгын олон өнгө аяс бүхий хэлцүүдийг жишээлэн авч үзэж болохоор байна.

Монгол хүний хувьд мал бол хэд хэдэн онцгой учир холбогдолтой зүйл болно. Тухайлбал, эртнээс нааш амьдарлынх нь үндэс болсоор ирсний хувьд хамгийн сайн таньж мэдсэн, хамгийн олон янзаар, хамгийн гарамгай эрхшээж чаддаг болсон амьтан нь даруй таван хошуу мал бололтой. Тэгээд ч тэдний зарим нь “их ухаантай” (морь гэх мэт) бол зарим нь “нэлээд тэнэг” (үхэр гэх мэт) гэсэн танилт үзэл ч бий. Хэдий тийм боловч хүн өөрийгөө ямар ч “ухаантай” мал амьтантай үлгэрлэшгүй, дээд эрэмбэ, дээд “ертөнцийн” бодгаль гэж үздэг учраас “тэнэг”-ийн монгол эталон буюу жишиг хэмжүүр нь “мал” ажээ. Тиймээс мал шиг тэнэг гэх буюу заримдаа бие биенээ шууд л “мал” гэлцдэг.

А. Хүний ухааныг цээжинд байна гэж үзэх нь:

Юмыг ухаарч ойлгохгүй хүнийг “Ухаан нь ууцандаа, санаа нь сүүжиндээ” гэж хэлэх бөгөөд уг хэлцийн санааг бүтээх хэмжүүр (эталон)-ээр ууц, сүүжийг сонгосон байна. Энэ нь нэг талаас, хүн төрөлхтөн хүний биеийг цээж, бөгс гэсэн хоёр зүйлд хуваан үзэж байсан бөгөөд нэгийг нь дээр байрладаг, цэвэр юмыг агуулдаг, нөгөөг нь доор байрладаг, бохир юм (шээс баас)-ыг агуулдаг гэж үзсэнээс үүдэн, эерэг, сөрөг үнэлэмжтэй болгосон байна. Тэгэхээр аливаа юм орших орон, байрлах байртай, тэдгээр нь бүгд зүй тогтол, эрэмбээрээ л байна. Харин тэрхүү орших газрын эрэмбэ нь алдагдахаар, тодруулбал, ухаан нь ууцандаа, санаа нь сүүжиндээ орохоор “тэнэг” болох мэтээр төсөөлөн ойлгосон хэмээн хэлж болмоор байна. Энэ нь хүний ухаан цээжиндээ байна гэж үзсээр ирсэнтэй холбоотой.

Ташрамд тэмдэглэхэд бидний одоо хэлэлцдэг “цээжлэх”, “цээж сайтай хүн” (цээж муутай хүн),



“цээжний бангаар ярих” зэрэг үг хэллэгийн анхдагч утга нь юмыг тогтоох, хадгалах ой ухааны “орон” нь даруй цээжний хөндийд байдаг гэсэн гэнэн (naive) ойлголт байсантай холбон үзэх боломжтой юм. Иймэрхүү төсөөлөл ойлголт нь Монголоос өөр соёл- хэлтэнд ч гэсэн түгээмэл байдаг гэсэн баримт бий.

“Монголын нууц товчоо”-ны 96-р зүйлийн төгсгөлд:

“Бөкэрэ-ийн бөксө-түр

Чэжэрэ-ийн чэгэжи-түр атухай” гэсэн маш сонин зүйр үг бий бөгөөд үүнийг академич Ц.Дамдинсүрэн

“Бөөр нь бөгсөнд байг, цэр нь цээжинд байг”; Ш.Гаадамба цээр мэт бохир зүйл цээжинд байх нь зохисгүй, харин бөгс бол бохир зүйл орших орон байх учиртай гэж үзсэн бололтой “Бохирын (муугийн) бөгсөнд, цэврийн (сайны) цээжинд атугай” хэмээн сэргээн сийрүүлээд үүнийхээ тайлбар өгүүлэлд: “Бидний бодлоор бол энэ өвөрмөц хэллэг бохир (муу) ину бөксэ дүр, (сүүлд) цэвэр (сайн) ину чэгэжи дүр (эхэнд) атугай (байтугай) гэсэн үг байсныг хятад галиглагч ба хадмал орчуулга үйлдэгч нар ойлголтгүй “бокир” гэдгийг “бөгэрэ” гэж буруу уншиж, буруу галигласан ба ташаа орчуулжээ” гэж бичсэн байна. Энэ тухайд академич Д.Цэрэнсодном “Монгол хэлд бөөр хэмээх нь хүний биеийн усны тунгалгийг боловсруулах үйлдэл бүхий таван цулын нэгийг нэрлэхээс гадна эр бэлгийн засаа, төмсийг бас “бөөр” гэдэг байна. ...“Бөөрөө бөгсөнд, цээрээ цээжинд атугай” хэмээн сурган хэлсэн эл үг нь нууцлах далдлах зохистой зүйлээ нууцалж хадгалж явтугай гэсэн гүн гүнзгий утга санаатай сургаал ажээ”⁵ гэсэн байна.

Бас нэг зүйлийг үүнд холбогдуулан тэмдэглэвэл, Ж.Лакофф⁶ англи соёл- хэлтний хувьд “UP” (дээшээ) нь “GOOD” (сайн), “DOWN” (доошоо) нь “BAD” (муу) гэсэн утгатай байдаг хэмээн “conceptual metaphor”-ын нэг зүйлийг жишээлэн өгүүлсэн нь бидний дээр үзүүлсэн хүний биеийн дээд бие буюу цээжин бие, доод бие буюу бөгсөн бие, тэдгээрийн тухай үнэлэмжийн онцлогийг гаргах гэсэн санаатай бас холбоо хамааралтай гэж үзэж байна.

“Монгол хэлэнд К.Юнгийн анима анимус гэсэн анхдагч дүр (археотип) хадгалагдсаар байна. ...эртний

⁵ Д.Цэрэнсодном. Монголын нууц товчооны утгазүй, уран сайхны шинжилгээ, Уб., 2008, 104-105

⁶ Lacoфф J. & Johnson M. Metaphors we live by. Chicago, 1980

анхдагч дүр нь ухамсраас гадуур бий болох ба төрөлх шинжтэй, учир шалтгааны холбогдолтой ба бие даасан шинжтэй ажээ. Анхдагч шинж нь үеэс үед үлгэр домог, утга зохиол урлагийн зүйлд уламжлагдан давтагдахдаа бэлгэдлийн шинжтэй байдаг”⁷ Үүнийг дээрх хэлцийг бүтээх жишиг хэмжүүрээр яагаад заавал сүүжийг сонгох болсонтой холбон тайлбарлаж болно. Монголчууд малын махыг хүнсэнд хэрэглэхдээ өдрийн өл залгах хоол хүнс төдийгөөр хязгаарлалгүй заншил ёс, шүтлэг бишрэлийн онцгой учир холбогдолтой хэмээн ханддаг байсан. Тухайлбал, махан зоог барих ёсонд сүүж, богтос, богино хавирга, далны мөгөөрс, өвчүүний бүдэрхийг хүндэтгэлийн маханд оруулдаггүй бөгөөд эмэгтэй хүнд сүүж, дунд чөмөг, өвчүү зэргийг тавьдаг байжээ. Тэр ч байтугай нүдийг нь авсан толгой, нүхий нь ухсан сүүж, нүнжгий нь хуулсан далны ясыг зочинд үзүүлэхгүйг хичээдгээс гадна гэртээ хонуулахыг одоо ч төвддөггүй. Учир нь, тэдгээрт чөтгөр орогнодог, хэрэв сүүжний нүхийг сэтэлж хаяхгүй бол үхээрийн сүнс хоргодон, сүр сүлд нь буурна гэж үздэгээс үүдэн сахиж байгаа дом. Ийм ч учраас баатарлагийн туульд харвасан сум нь сүүжний нүхээр гаран, алтан мөнгөн тэвнийг онож байгаагаар гардаг нь сүүжний ясан дахь чөтгөрийг дарж байгаа хэрэг хэмээн битүү егөөдсөн санаа байж магадгүй юм. “Ялангуяа сүүжний ясыг хамгийн муу муухайн бэлгэдэл болгов... урьд гэмт хэрэг хийсэн хүний аман хайланг авахын тулд доогуур нь мөлхүүлдэг шахааны хэцэнд өлгөдөг элдэв бузар муухай юмсын нэгэнд оруулдаг байв”⁸

Нөгөөтэйгүүр, монгол хүний ухаарлаар ухаан нь хөндий, уудам талбай бүхий цээжин дотор үргэлж чөлөөтэй хөдөлж, гүйлгээ ухаан суух ёстой атал үүнийг биеийн хэсэгтэй харьцуулахад бүхэл цул биеийн хэсэг болох “ууц (нурууны сээрээс хойш ахар сүүл хүртэлх хэсэг, харцага), сүүж (хүн, амьтны гуяны дунд чөмөгний дээд этгээдэд ууцтай холболдон байдаг нүхтэй яс)”-нд ухаан орох юм бол мулгуу тэнэг болох мэтээр сэтгэхүйн ертөнцдөө төсөөлөн дүрсэлсэн онцлог харагдаж байна. Хүн, амьтны бэлхүүс, хүзүү хоёрын хоорондох хэсгийг цээж гэх бөгөөд *цээжний хөндий* (өрцнөөс дээших хөндий, хэнхдэг), *цээжний хэнгэрцэг* (өвчүү, хавирга, сээрний яснаас бүрдсэн шоовон хэлбэртэй ясан хайрцаг) гэх нь бий. Монгол хүн цээжийг “багтаамжтай” гэсэн утгаар ойлгодог, аливаа зүйлийн учрыг олсондоо баярлахын сацуу уужирч тайвширдаг. Ийм ч учраас “*цээж уужрах* (а.цээж дүүрэхээ болих, б.сэтгэл санаа тайвшрах), *цээж онгойх* (ухаан санаа уужрах), *цээж тэнийх* (сэтгэлийн зовлон дарамт арилах), *цээж уудлах* (санасан бодсоноо нуулгүй, бүгдийг ярих, хэлэх), *цээж сайтай* (хүний оюун ухаан хурц, сэргэлэн, юмыг мартдаггүй), *цээж ихтэй* (үзсэн сонссоноо мартдаггүй хүн; цээжтэй), *цээж саруул* (ухаан санаа, ухаан бодол уужуу), *цээж дүүрэн* (сэтгэл санаа баясгалантай), *цээжээр бичих* (бодсон санасан, тогтоосон зүйлээ бичих), *цээжээ хавтаслах* (ном эрдэмтэй болох, ном зохиол их уншиж мэдлэгтэй болох), *цээжийн бөх* (ухаантай, мэргэн цэцэн), *эр хүний цээжинд, эмээлтэй хазаартай морь багтана* (эр хүний ухаан бодол уужуу) гэхээс гадна *цээж муутай* (юм тогтоохдоо муу), *хөндий цээж* (юу ч мэдэхгүй мөртлөө мэдэмхийрдэг, бардам сагсуу), *цээж түрэх ~ цээж тэлэх* (а.цээжээ урагш болгох, б.омгорхог зан ааш гаргах, ханхалзах), *цээжнийхээ махыг барж идэх* (сэтгэл туйлын их зовох), *аавын цээж* (хаахгар, их зантай, давилуун хөвгүүн), *аавын цээж гаргах* (нас бага хүүхэд, хаахгар, давилуун зан гаргах)” гэж сөргөөр хэлэх нь ч бий.

Монгол хүний үзлээр ухааныг хөндий, уужим зай бүхий цээжин дотор үргэлж бясалгаж хөдөлгөж байх ёстой атал тэрхүү хөдөлгөөнийг хязгаарлах юм бол мулгуу тэнэг болох мэтээр сэтгэхүйн ертөнцдөө төсөөлөн дүрсэлдэг онцлог нь “*Ухааныг уяж болохгүй, санааг савлаж болохгүй*” гэсэн хэллэгээр илэрч байна.

Монголчууд “*Ухаанд нь ухна үхсэн, санаанд нь сарлаг үхсэн*” гэж хэлдэг. Гэтэл хамгийн сайн мэдэх малаасаа тэмээг биш, ямааг биш яагаад заавал ухна (хөнгөлж засаагүй эр ямаа), сарлаг (хүзүү, дөрвөн мөч охор, сээр өндөр, урт үстэй нэг зүйл үхэр)-ийг сонгов? Учир нь монгол хүн ухныг дараах байдлаар ойлгодог ажээ. Үүнд:

- *ухна царайлах (уруу царайлах, унхиагүй байх)*
- *халтар ухна (бохир заваан)*
- *халтар ухна болох (бохиртох, заваан болох)*
- *Ухна шиг эс аашилах аашигүй*
- *Улиг хүн эс загнах зангүй*
- *Ухна шиг бүү бавтна*
- *Буур шиг бүү галзуур*
- *Ухнын бие нь үзэгдэхгүй заар нь ханхлах*
- *Уршигтын бие нь харагдахгүй зар нь хангинах*
- *Баруун зүгийн бам хар тангад*
- *Загал хошуутай, зааран хормойтой*
- *Зай завсаргүй тарнидна (Ухна)*
- *Дээрээ хоёр жадтай, доороо хоёр домботой*
- *Аймаар хури нүдтэй, анхил ханхил үнэртэй (Ухна)*
- *Урт шар илдтэй, уранхай навтас дээлтэй*
- *Унжуу цагаан сахалтай, үглүүр бавтнуур заарт (Ухна)*

зэргээс үзвэл, ухнын дүр зураг нь үзэх нүднээ сүр их, навсайж нэвсийсэн, заар зангаг ханхалсан,

⁷ М.Базаррагчаа. Монгол хэлний сүгээр ба найруулбарын тухай. УБ., 2003, 8-9

⁸ Г.Ловор. Учир мэдэхгүй хүнд ууц битгий тавь. УБ., 2002, 6

тодруулбал, хөгшрөх тусмаа заар нь ихэсч, чадал нь багасдаг амьтан ажээ. Ийнхүү хөндий, уужим зай бүхий цээж буюу ухаанд нь хэжим (гэдэсний дагуу ургасан урт үс), саваг үс (сарлагийн хэжлүүрийг дагаж ургасан болон биеийн бусад хэсгийн үс) ихтэй, газартай үргэлжлэн ороолдсон, нэвсгэр том амьтан (ухна, сарлаг) ороод үхсэнтэй адилтгаж хэтрүүлсэн нь уг хэлцийн санааг бүтээх хэмжүүр (эталон) болсон ухна, сарлагийн гадаад дүрийн төстэй шинжид тулгуурлажээ. Энэ нь монголчуудын сэтгэхүйн өвөрмөц дүр зураг болжээ.

“Ухаанд нь ус орж, санаанд нь шавар орох” гэсэн хэлцийн тухайд, уг хэлцийн санааг бүтээх хэмжүүр (эталон)-ээр ус, шаврыг сонгосон нь малыг амьжиргааныхаа эх үндэс болгож ирсэн монголчууд хамгийн сайн мэдэх цагаан идээтэйгээ холбож, усыг шимгүй, сүүг шимтэй хэмээн эсрэгцүүлэн үздэгтэй холбоотой аж. Энэ мэтээс үүдэж *усан тэнэг* (юу ч мэдэхгүй, туйлын мангуу), *усан толгой* (мангуу), *усан нүдлэх* (уйлах), *усан нүдэт* (уйланхай), *усан гүзээ болох* (шалба норох, нэвт норох), *усан чөдөр* (цай нь болохгүй хүлээлгэх), *усан амтай* (дандаа бүтэлгүй юм ярьж явдаг), *ус болох* (хор болох, саад болох), *ус балгасан юм шиг* (үг дуугарч чадахгүй гөлөлзөх, яахаа мэдэхээ болих), *гал ус хоёр шиг* (хоорондоо харшилдсан, огт таарч тохирохгүй), *олгойтой ус шиг* (эв хавгүй, хэлбэр галбир муутай) гэх мэтчилэн сөргөөр хэлэх нь олонтоо байна. Харин сүүг шимтэй хэмээн эрхэмлэдгийн илрэл нь *сүү шиг дотортой* (цагаан санаатай, сайхан сэтгэлтэй), *сүүний хариу цус* (ачийг өшөөгөөр, сайныг муугаар хариулах), *сүүтэй л бол эх* (биед нь ашигтай л бол сайн), *сүү мэт цагаан сэтгэлтэй, түлхүүр мэт уран гартай* (сэтгэл сайхан, ажилд чадамгай), *сүүн мөртэй* (сайн, бэлгэшээлтэй), *сүүгүй цай хар, сүсэггүй сэтгэл хар* (хүн итгэх бишрэх юмгүй, айж ичих зүйлгүй байх нь муу), *сүү хийсэн савнаас үнэр нь гарахгүй, сур иддэг нохойны ховдог нь гарахгүй* (сурсан занг болиход хэцүү), *сүү гашилбал язмаг, мэргэд ганцаардвал өнчин* (хань нөхөр, ах дүүгүй ганцаардах хэцүү) зэрэг хэллэгээс тодорхой харагдаж байна. “Гэхдээ энэ нь монгол хүн усыг хэрэггүй, тусгүй зүйл гэж үздэг гэсэн үг биш, харин ч “Амьдралыг тэтгэгч гурван чандмань эрдэнийн нэг нь ус мөн” гэж ардын үлгэр домогт гардаг. Гагцхүү сүүтэй харьцуулсан үнэлэмжээс л харшууллын энэ утга санаа үүсэх болсныг тэмдэглэх хэрэгтэй болсон юмаа”⁹ Иймд ус, сүү хоёр бол шимтэй- шимгүй эсрэгцлийн жишиг хэмжүүр болж тогтжээ. Түүнчлэн “сүү гашлах”-ийг “гавал нь гашлах, тархи нь гашилсан” гэсэн нь “сүү”-г “гавал/тархи”-аар сольсон тойруулал болно.

Б. Хүний ухааныг гэрлээр хэмжих нь:

Тэнэг хүнийг “хүүдэг нь битүү”, “хойшоо харсан нүх” гэдэг нь ухааныг гэрлээр хэмжихээс үүдсэн гэж хэлж болно. Энэ тухайд эрдэмтэн М.Базаррагчаа “Ухаантай хүнийг гэгээн (гэ-гэ-(гэ)-н) гэдэг нь ухаантай хүнээс гэгээ цацардаг гэж үзэж байсантай холбоотой бөгөөд энэ нь К.Юнгийн анхдагч төгслөг шинж юм. Энэ шинж нь 35-40 наснаа тохиох бөгөөд үлгэр домогт мэргэн өвгөн, бөө удган, эрэлхэг баатрын дүрээр илэрдэг ажээ. Үүний эсрэг тэнэг хаан, тэнэг хүү, хулчгар эр зэрэг дүрүүд байдаг нь сүүдэр гэдэг эртний анхдагч дүр юм”¹⁰ гэжээ. “хойшоо харсан нүх” гэсэн хэлцийн тухайд харааж зүхсэн аясыг илэрхийлэх бөгөөд Монголын салхи баруун хойноос голдуу гардаг учир хойшоо харсан нүхэнд нарны гэрэл тусахгүйн зэрэгцээ амьтан орогнох магадлал бага байдагтай холбоотой гэж хэлж болно.

Энэ мэтээс үзэхэд, юуны урьд малыг таньсан танилт, ухаарал ойлголтыг адилтгагдахуун буюу зүйрлэгдэхүүн болгож байгааг үндэслэл болговол, монгол сэтгэлгээний “тэнэг” хэмээх багцалмал мэдлэг (concept)-ийн нэг гол эталон нь мал болох нь бидний сонгон жишээлсэн олонх хэлцээс харагдаж байна. Ингэхлээр “тэнэг” хэмээх утгыг илэрхийлэх хэлцүүд нь дотроо ёжилж егөөдсөн, доромжлон доршоож үзсэн, харааж зүхсэн, өрөвдөж харамссан зэрэг олон өнгө аястай байгааг тус бүр олон жишээгээр задлан нарийвчлах боломжтой. Цухас төдийг дурдвал, “үхэр хэдгэнийг дээсээр бугуйлдах” нь егөөдлөөр бүтсэн бөгөөд бага- том хоёрыг эсрэгцэлдүүлэн, өнгөц харахад сайнаар буюу жирийн хэлсэн мэт ч угтаа муугаар егөж, шүүмжлэх санаа илтгэн, зүй тогтлыг урвуу аргаар эвдсэн байна.

Хүний ухаан цээжинд байдаг гэж үзэхийн зэрэгцээ үргэлж чөлөөтэй хөдөлж байдаг мэтээр сэтгэхүйн ертөнцдөө төсөөлөн дүрсэлдэг онцлог нь бидний жишээлэн авсан ихэнх хэлцээр илэрч байна. Үүнээс үүдэн “Хүний цээж бол гүйлгээ ухаан суух ОРОН юм” хэмээн тодорхойлж болно гэж үзвэл энэ нь Ж.Лакоффын “conceptual metaphor” гэдэгтэй хавьтах дүгнэлт болж болох юм гэж үзэж байна. Түүнчлэн ухааныг гэрлээр хэмжих буюу гэрэл сүүдрийн тухай ухагдахууныг К.Юнгийн төгслөг ба сүүдэр гэсэн анхдагч хэв шинжтэй холбон тайлбарлаж болох нь хэлний баримтаас харагдаж байна.

SUMMARY

We aimed to determine the standard to express the meaning of “stupid”, and also tried to explain it’s reason of habit. Hence phrases have been as expression of thinking style and recognition the earth of nations it is important to recognize the reason why it’s named so and to reveal it’s basic idea which formed it.

Mongolian says “bucks dead in conception”, “yak dead in mind”. But why it is not the most well - known animal camel and goats, why are bucks, (male goat which is not castrated), Yak (neck and four legs are short, spine is tall,

⁹ Ж.Баянсан. Хэл, соёл, сэтгэлгээ. Уб., 2002, 7

¹⁰ М.Базаррагчаа. Монгол хэлний сүгээр ба найруулбарын тухай. УБ., 2003, 8

long hair, one kind of cow) are selected? Mongolian people pictures bucks like more powerful, shaggy and ragged, musk- strong odour smelled animal. Thus, valleys and wide chest with a space or in conception (intestinal grown under long hair), steal hair (rest of the body hair) with always the entangled crinite the shaggy big animals (goats, yaks), and the dead, excessive compared created the idea of the phrases (in reference) bucks and yak overseas role, based on similar factors. This the unique Mongolian mental picture.

To sum up, when people comparing himself with people and animals, and the animals and their species - related measures with the word “stupid” in the meaning observed in the language documentation. The “dumb” mean value of phrases as fine seed is usually considered in relation to identity, exaggerated. For example: “catch the humblebee with ropes” by opposing small and large things, and trying to show with physical forms, so broke the a parallel pattern identification method.

Ашигласан ном

- Базаррагчаа М. Монгол хэлний сүгэгэр ба найруулбарын тухай. Уб., 2003
Баттогтох Д. Үлгэрийн хэлц үгийн толь. Уб., 2013
Баянсан Ж. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, Уб., 2002
Lacoff J. & Johnson M. Metaphors we live by. Chicago, 1980
Ловор Г. Учир мэдэхгүй хүнд ууц битгий тавь. Уб., 2002
Маслова В.А. Лингвокультурология. М., 2002
Телия В.Н. Русская фразеология. Семантический, прагматический и лингвокультурологические аспекты. М., 1996
Цэрэнсодном Д. Монголын нууц товчооны утгазүй, уран сайхны шинжилгээ, Уб., 2008